Төрийн албаны зөвлөлийн
2020 оны дугаар сарын 09-ний өдрийн
309 дүгээр тогтоолын 31 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Биеийн тамир, спортын улсын хороо | Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Боловсролын байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамирын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-6 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдрийн 8 цаг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо,Бага тойруу 55, Спортын төв ордон. |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдыг биеийн тамирын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

| Албан тушаалын зорилт:<br>1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамирын үйл ажиллагаанд татан оролцуулах, паралимпийн хөтөлбөрт багтдаг спортын төрлүүдийг сурталчлах, хөгжүүлэх;<br>2.Бүх шатны боловсролын байгууллагад суралцагчид, ажилтан, албан хаагчдын биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах, сургалт зохиох, судалгаа хийх;<br>3.Биеийн тамирын хичээлийн хөтөлбөр, агуулга, арга зүйг боловсронгуй болгоход мэргэжлийн санал дүгнэлт боловсруулах, зөвлөмжөөр хангах;<br>4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | | | |
|---|---|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамир, спорт, нийтийг хамарсан ажил үйлчилгээний удирдамж, зөвлөмж боловсруулах, үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, үр дүнг тооцох; | Биеийн тамираар хичээллэгчдийн тоо, спортын төрлүүд нэмэгдсэн байна. | Г |
| | 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамираар хичээллэх, мэдлэгийг дээшлүүлэхэд шаардлагатай гарын авлагаар хангах, сургалт, сурталчилгаа зохиох; | Сургалт зохиогдож, сурталчилгааны гарын авлага боловсруулсан байна. | Г |
| | 3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аж ахуйн нэгж, байгууллагаас зохиогдох биеийн тамир, спортын үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг бодлогоор дэмжих, сурталчлах, урамшуулах ажлыг зохион байгуулах; | Төсөл, арга хэмжээг бодлогоор дэмжих, сурталчлах, урамшуулах ажлыг зохион байгуулсан байна. | Г |
| | 4.Паралимп, дифлимп, тусгай олимпын хөтөлбөрт багтдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын байгууллага, холбоодтой хамтран | Холбогдох спортын байгууллага, холбоодтой хамтын ажилласан байна. | Г |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ...ТЭРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллах. | | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүх шатны боловсролын байгууллагад суралцагчид, ажилчид, биеийн тамирын багш нарыг шаардлагатай мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | Шаардлагатай мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн зохион байгуулагдсан байна. | Г |
| | 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдыг биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх секц, дугуйлан, клубийн тоог нэмэгдүүлэх, хичээллэх боломжийг бүрдүүлэх; | Биеийн тамираар хичээллэх орчин бүрдсэн байна. | Г |
| | 3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, суралцагчдын дунд биеийн тамирын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах. | Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зохион байгуулсан байна. | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Биеийн тамирын хичээлд ордоггүй суралцагчдад зориулсан хөтөлбөр боловсруулах, асуудлыг судалж санал, дүгнэлт боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; | Судалгааны үндсэн дээр санал дүгнэлт боловсруулсан байна. | Г |
| | 2.Биеийн тамирын хичээлийн хөтөлбөр, агуулга, арга зүйг боловсронгуй болгоход мэргэжлийн санал, дүгнэлтийг судалгааны үндэслэлтэй боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлэх; | Биеийн тамирын хичээлийн хөтөлбөр, агуулга, арга зүйг боловсронгуй болно. | Г |

МОНГОЛ УЛС ... ЗӨВШӨӨРӨВ ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Бүх шатны боловсролын байгууллагын ажилчид, суралцагчдаас бие бялдрын түвшин тогтоох сорил авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, улсын мэдээллийн санд оруулах, бие бялдрын түвшнийг сайжруулах үйл ажиллагааг зохиох, хяналт тавих. | Бие бялдрын түвшин тогтоох сорил авагдаж, бие бялдрын түвшнийг сайжруулах ажлыг зохион байгуулсан байна. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь гүйцэтгэх; | Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. | Г, Х |
| | 2.Агентлагийн удирдлага бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, хугацаанд нь гаргаж өгөх; | Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна. | Г |
| | 3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Байгууллагын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах; | Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна. | Г |
| | 4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх; | Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. | Г, Т, Х |

| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | |
|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | -спорт /1014/;<br>-багш,биеийн тамирын боловсрол /011410/;<br>-спортын менежмент. |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗОВШООРОВ

| | | |
|---|---|---|
| Мэргэшил | Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байх. | |
| Туршлага | Төрийн албанд эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, харьцуулалт хийх;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;<br>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, харилцааны соёлыг эрхэмлэх;<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа зэрэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах;<br>- мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах;<br>- хамт олны зэрэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;<br>- бусад. |
| | Бусад | - харилцааны соёлыг эрхэмлэх;<br>- албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи, ашиглах чадвартай байх;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх. |

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

<table>
<tr><td colspan="2"><u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u><br>Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга.</td></tr>
<tr><td><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></td><td><u>Бусад харилцах субъект:</u><br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар, хэлтэс;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Иргэн хуулийн этгээд.</td></tr>
<tr><td colspan="2">V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</td></tr>
<tr><td><u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u></td><td><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></td></tr>
<tr><td><u>Албан тушаал:</u><br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br>.................................... Т. Одбаатар<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2020 оны 09 дугаар сарын 28-ны өдөр<br>9020080967 4 9111891</td><td><u>Байгууллагын нэр:</u><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><u>Шийдвэрийн огноо:</u> 20.09.09<br><u>Дугаар:</u> 309</td></tr>
<tr><td colspan="2">Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</td></tr>
<tr><td colspan="2"><u>Байгууллагын нэр:</u><br>БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО<br><u>Шийдвэрийн огноо:</u> 2020.9.28<br><u>Дугаар:</u> Б/08<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА .......................... Ц. ШАРАВЖАМЦ<br>2020 оны 9 дугаар сарын 28-ны өдөр</td></tr>
</table>

МОНГОЛ УЛС<br>ЗӨВШӨӨРӨВ<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ